

ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН

Дд	Үзүүлэлт	Тайлбар
1	Төслийн нэр	"Зүүн цагаан дэл"-ийн хайлуур жоншны ордыг далд аргаар ашиглах
2	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн нэр	Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого; Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
3	Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан зорилго, зорилт	Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ. Газрын тос, нүүрс-хими, зэсийн баяжмал, төмөрлөг зэрэг хүнд үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, холбогдох дэд бүтцийн төслүүдийг хэрэгжүүлнэ.
4	Төслийн зорилго, зорилт	“Зүүн цагаан дэл”-ийн хайлуур жоншны ордыг далд уурхайн аргаар эдийн засгийн үр ашигтай ашиглах, олборлолтын хэмжээг нэмэгдүүлэх, нөөцийн ашиглалтыг сайжруулах, экспортын чадавх болон үйлдвэрийн газрын орлогыг өсгөх, орон нутагт ажлын байр, эдийн засгийн идэвхжилийг нэмэгдүүлэхэд оршино.
5	Төслийн гүйцэтгэл, явц	<p>Зүүн Цагаан дэлийн хайлуур жоншны ордын далд уурхайн төслийн бэлтгэл, дэд бүтэц, үндсэн ажлууд бүрэн хангагдаж, олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн. Төслийн хүрээнд дараах ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлээд байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Далд уурхайг ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийг мэргэжлийн зөвлөлийн салбар хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, төслийн хэрэгжилтийг батлагдсан төлөвлөгөөний дагуу үргэлжлүүлж байна. ➤ Уулын ажлын төлөвлөгөө, тайланг жил бүр боловсруулан батлуулж, үйл ажиллагааг батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг хэрэгжүүлж байна. ➤ Уурхайн хүдэр ялгах цехийн зураг төсөл боловсруулах ажлын хүрээнд харьцуулалтын тооцоог хийж дуусгасан. ➤ Уурхайн хэмжээнд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ болон ажлын байрны эрсдэлийн үнэлгээг холбогдох журмын дагуу хийж гүйцэтгэсэн. ➤ Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу бүрэн хийж гүйцэтгэсэн. ➤ Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан батлуулсан. ➤ Уурхайн цахилгаан хангамжийн хүрээнд 6000 кВт хүчин чадалтай, 3.5 км урт агаарын цахилгаан дамжуулах шугамыг барьж, дэд станцын ажлыг бүрэн гүйцэтгэсэн. ➤ Автогараж болон оффисын зориулалттай нэг давхар барилгын засварын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. ➤ Ажиллагсдын 104 хүний амрах зориулалттай 1, 2 дугаар байрыг ашиглалтад оруулсан. ➤ Тэсрэх бодисын агуулахын барилгын ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн. ➤ Далд уурхайн агааржуулалтын босоо малталт болон хүдэр олборлолтын бэлтгэл малталтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэж байна. ➤ 2025 оны 10 дугаар сараас эхлэн хүдэр олборлолтын үйл ажиллагааг эхлүүлсэн.